



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖИНСТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 18 өдөр


Дугаар 2/19

Бодь

┌ Хурлын хороод байгуулах тухай ─┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 21.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2 дугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:


1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд хороодыг байгуулж, ажиллуулсугай.
2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын хороодын бүрэлдхүүнийг 1 дүгээр, ажлын хороодын ажлын чиг үүргийг 2 дугаар, ажлын хороодын ажиллах журмыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Хийж хэрэгжүүлэх ажлын чиг үүргийн дагуу ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хагас бүтэн жилээр Тэргүүлэгчдийн хуралдаанд тайлагнаж байхыг хурлын хороодын дарга нарт даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /М.Ган-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.



ДАРГА

ДАМАР-АМГАЛАН

1000



1000



Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны  
12 дугаар сарын 18-ны өдрийн 2 дугаар хуралдааны  
2/19 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

## ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХОРООДЫН БҮРЭЛДЭХҮҮН

Нэг: Нийгмийн хамгаалал, хөгжлийн асуудал эрхэлсэн хурлын хороо:

Хорооны дарга : С.Батчимэг /иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч,  
Тэргүүлэгч/

Гишүүд : Б.Батчулуун /иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Д.Болдбаатар /иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч/

Ц.Ганбаасан /иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч/

О.Батдорж /иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч/

Д.Наранбаатар /иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч,Тэргүүлэгч/

Хоёр. Хууль, эрх зүй, төрийн байгуулалтын бодлогын асуудал эрхэлсэн хурлын хороо:

Хорооны дарга: Н.Жаргалсайхан /иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч/

Гишүүд: Ц.Төмөрбат /иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч/

Л.Сугармаа /иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч/

Ц.Хишигхүү /иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч/

Ц.Эрдэнэбаатар /иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч,

Тэргүүлэгч/

Г.Амарбат /иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч/

Гурав. Хүнс хөдөө аж ахуй, байгаль орчин, газар, дэд бүтцийн бодлогын асуудал  
эрхэлсэн хурлын хороо

Хорооны дарга Б.Батбаяр /иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч,  
Тэргүүлэгч/

Гишүүд : С.Цогзолмаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч/

Б.Мөнхбат /иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч/

Ж.Батсайхан /иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч/

О.Жин /иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч/

Ц.Баяр-Өлзий /иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч/





## СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХОРООДЫН АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРЭГ

### **Нэг. Хороодын ерөнхий чиг үүрэг:**

- 1.1 Хариуцсан салбарын чиглэлээр судалгаа хийх
- 1.2 Тулгамдаж буй асуудлыг бодлого, шийдвэрт тусгуулах
- 1.3 Хууль, тогтоомж, хурлаас батлан гаргасан ажлын чиг үүргийг сурталчлах
- 1.4 Хариуцсан салбараас хуралдаанд хэлэлцэх асуудлыг хорооны хурлаар урьдчилан хэлэлцэх
- 1.5 Хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах
- 1.6 Иргэдийн өргөдөл, санал хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлүүлэх

### **Хоёр. Хууль, эрх зүй, төрийн байгуулалтын бодлогын асуудал эрхэлсэн хурлын хорооны ажиллах чиг үүрэг:**

- 2.1 Сумын нийгмийн хэв журмыг хангуулах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх
- 2.2 Хүний эрх, эрх чөлөө, түүний баталгаа
- 2.3 Сумын төр, захиргааны байгууллага
- 2.4 Сүм хийд, шашин, төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагууд
- 2.5 Санхүү, зээл болон татварын бодлого
- 2.6 Сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилт
- 2.7 Өмчийн асуудал

### **Гурав. Нийгмийн бодлого, хамгаалал, хөгжлийн асуудал эрхэлсэн хурлын хорооны ажиллах чиг үүрэг:**

- 3.1. Эрүүл мэнд
- 3.2. Боловсрол, соёл, урлаг





3.3. Нийгмийн хамгаалал

3.4. Биеийн тамир, спорт

3.5. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр хамгаалал

3.6. Сумын түүх, соёлын өвийг хамгаалах, сэргээх/аялал, жуулчлал/

**Дөрөв. Хүнс хөдөө аж ахуй, байгаль орчин, газар, дэд бүтцийн бодлогын асуудал эрхэлсэн хурлын хорооны ажиллах чиг үүрэг:**

4.1 Газар тариалан, мал аж ахуйн бодлого, хөдөө аж ахуйн салбарын хөгжил, энэ чиглэлээрх зээл тусламж

4.2 Жижиг дунд үйлдвэрлэл, аж ахуй эрхлэлтийг дэмжих

4.3 Байгаль орчны бодлого, хөрс, ус, ой, амьтан, ургамал хамгаалал, байгаль орчны хяналт

4.4 Ан амьтны агнуурын нөөцийг зохистой ашиглах

4.5 Цаг уур, орчны хяналт

4.6 Усны бодлогын хэрэгжилт, хяналт, нөөц, усны бохирдол

4.7 Барилга, хот байгуулалт, газар зохион байгуулалт, төлөвлөлт

4.8 Зам тээвэр, харилцаа холбоо





Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны  
12 дугаар сарын 18-ны өдрийн 2 дугаар хуралдааны  
2/19 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ХОРООДЫН АЖИЛЛАХ ЖУРАМ



Нэг. Зорилго нь:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хурлын байгууллагын үйл ажиллагааг тогтмолжуулах, сумын ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал дүгнэлт гаргах, хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах, сумын эдийн засаг, нийгмийн амьдралын олон талт асуудлыг шийдвэрлэж хурлын тасралтгүй байнгын үйл ажиллагааг хангахад оршино.

Хоёр. Хурлын хороо нь дараах байдлаар ажиллана

1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хурлын хороодтой байна.
2. Хурлын хороо нь даргатай байна.
3. Хурлын хорооны дарга, гишүүд нь орон тооны бус байна.
4. Хурлын хорооны гишүүд бусад хурлын хороонд орж ажиллах эрх нь нээлттэй байна.
5. Хурлын хорооны үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байна.
6. Хурлын хороо нь хариуцсан чиглэлээр асуудлыг судалж, боловсруулах, шалгаж танилцах, санал дүгнэлт гаргах, сумын ИТХ-ын ээлжит болон ээлжит бус хуралдаан, Тэргүүлэгчдийн хуралдаанд асуудал боловсруулж хэлэлцүүлэх, гарсан шийдвэрийг сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтийг дүгнэх зэргээр ажиллана.
7. Хурлын хороод нь нутгийн өөрөө удирдах байгууллагын нэгэн бүрэлдэхүүн хэсэг болох учраас сумын нутаг дэвсгэрт ажиллаж амьдарч байгаа иргэд, хувийн хэвшил, аж ахуйн нэгж байгууллагуудыг оролцуулж, тэдний санал хүсэлт, туслалцааг авах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна.
8. Хурлын хорооны хурлыг хоёр сард нэгээс доошгүй удаа хуралдаан, бусад хороодын хуралтай давхцуулалгүйгээр хийнэ.
9. Хурлын хорооны хуралдааны шийдвэрийг сумын ИТХ, Тэргүүлэгчдийн шийдвэрээр баталгаажуулна.
10. Хурлын хороодын хуралдааныг хороонд сонгогдоон төлөөлөгчдийн олонх нь ирсэн бол хүчинтэйд тооцно.
11. Хурлын хороо хэлэлцсэн асуудлаараа тогтоолын төсөл, санал, дүгнэлт, зөвлөмж гаргах бөгөөд түүнийг тухайн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар батална.



гаргах бөгөөд түүнийг тухайн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар батална.

12. Хурлын хороо нь ажлын шаардлагаар холбогдох байгууллага, мэргэжилтэн, иргэнийг үйл ажиллагаандаа оролцуулж оновчтой зөв шийдвэр гаргахад ажлаа чиглүүлнэ.

13. Шаардлагатай тохиолдолд Тэргүүлэгчдийн шийдвэрээр ажлын хэсэг томилон ажиллуулж болно.

14. Хурлын хорооны хурлыг нээлттэй, өргөтгөсөн байдлаар зохион байгуулахдаа иргэдийн төлөөллийг оролцуулж болно.

15. Хурлын хороод нь сумын ИТХ болон Тэргүүлэгчдийн хуралдаанаас гаргасан тогтоолын хэрэгжилтийг хангуулж ажиллана.

16. Эрхлэх асуудлын хүрээнд олон нийтийг хамарсан урлаг, уран сайхан, соён гэгээрүүлэх, хууль сурталчлах ажлыг зохион байгуулж болох бөгөөд шаардагдах төсөв, санхүүгийн асуудлыг сумын ИТХ-ын дарга, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргатай зөвшилцөн шийдвэрлэнэ.

Гурав. Хурлын хорооны дарга нь дараах чиглэлийг баримтлан ажиллана

1. Хурлын хорооны дарга нь тухайн жилийн төлөвлөгөөг Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж хэрэгжилтэнд хяналт тавина.

2. Хурлын хорооны дарга нь хорооны гишүүдэд ажил үүргийн хуваарь гарган, шаардлагатай бол асуудал бэлтгэн боловсруулах ажлын хэсэг байгуулж бусад үүрэг гүйцэтгүүлж болно.

3. Хурлын хорооны дарга нь хурлаар хэлэлцэх асуудлын талаар санал гаргах, хурлаар хэлэлцүүлэх асуудлыг баталж хорооны хурлыг удирдан явуулна.


4. Хурлын хорооны дарга нь харьяалсан асуудлын хүрээнд холбогдох газар, хэлтэс, албаны үйл ажиллагаатай танилцах, мэдээ, мэдээлэл гаргуулж авах, удирдах ажилтныг дуудаж уулзах, шаардлагатай гэж үзвэл ИТХ-ын Тэргүүлэгчдэд асуудал оруулж шийдвэрлүүлнэ.

Дөрөв. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанаас хурлын хороодын өдөр тутмын үйл ажиллагааг дараах байдлаар хангаж ажиллана.

1. Хурлын хорооны өдөр тутмын үйл ажиллагааг хурлын нарийн бичгийн дарга хариуцан, хурлын хороодын дарга нартай байнгын холбоотой ажиллана. Эрхэлсэн асуудлын хүрээ холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөж ажиллана.

2. Хурлын хорооны хурлаар хэлэлцэх асуудлыг бэлтгэн хурлын хорооны гишүүдэд хоёроос доошгүй хоногийн дотор хүргүүлнэ.

3. ИТХ-ын нарийн бичгийн дарга нь хурлын хорооны дарга, төлөөлөгчдийг мэдээ, мэдээллээр хангах, хурлын хорооны хурлыг зохион байгуулах бэлтгэлийг хангах /хуралд оролцогчдод зар хүргэх/, хурлын байр, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах, хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг хурлын хорооны даргад танилцуулан гарын үсэг зуруулан



албажуулах, хурлын хорооноос гарах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах зэрэг ажлыг зохион байгуулна.

4. Сумын ИТХ-ын архив, бичиг хэргийн ажилтан нь хорооны хурлын тэмдэглэлийг хөтөлж, хурлын хорооны үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтыг архив, албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулан хөтөлнө.

5. ИТХ дахь нам эвслийн бүлэгтэй хамтран ажиллана.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

